

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ХҮНСНИЙ ХАНГАЛТЫН МЕНЕЖМЕНТ

Б.Мөнхтулга

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 7081 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн дэслэгч

Хураангуй: Орчин цагт цагдаагийн агентлаг, байгууллагууд хуулийн хүрээнд урд өмнөхөөс нэлээд өргөн үйл ажиллагаа явуулах болсон бөгөөд үндсэн чиг үүргийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, аюул осол болон гэнэтийн аливаа үйлдэл, нийгмийн эмх замбараагүй байдал, хар тамхи, шинэ төрлийн гэмт хэргүүд, хүн худалдаалах, цахим болон үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхийн зэрэгцээ иргэд, олон нийттэй үр дүнтэй харилцааг бэхжүүлэх зэрэг олон чиг үүргийг хэрэгжүүлж байна. Хүчний байгууллагын хүнсний аюулгүй байдлыг хангахад анхаарах зарим асуудлыг томъёолохын тулд хүнсний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлийн нөлөөллүүдийг цагдаагийн албаны хүнсний аюулгүй байдлын тухай онолын мэдлэг ямар төвшинд байгаа болон орчны үнэлгээнд хийсэн тойм судалгаа, цагдаагийн албаны хүнсний аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийг тодорхойлж, асуулгын аргаар судлан, шинжилж, цаашид анхаарах зарим санал дэвшүүлсэн болно.

Abstract: In modern times, police agencies and organizations have become more active within the framework of the law than ever before, and their primary responsibilities include crime prevention, traffic safety, safety and emergency response, social unrest, drugs, new types of crime, human trafficking, digital and multinational crimes, as well as citizens. and strengthening effective public relations. To identify some of the issues that the law enforcement agencies should focus on food security, we include an overview of the level of theoretical knowledge of food security in the police department and environmental assessments, and some recommendations for further consideration by identifying, interrogating, and examining the external and internal factors affecting the food safety of the police department.

Түлхүүр үг: Хүнсний хангалт, хоол хүнс, цагдаагийн алба хаагч (эрүүл мэнд) түргэн хоол

Keywords: Food supply, Food, Police (Health) Fast Food

Оршил: Дэлхийн хүн амын нийт өвчлөлийн 80 хувь нь хоол хүнснээс үүдэлтэй өвчлөлөөр өвчилдөг болохыг дэлхийн эрүүл мэндийн байгууллага

2019 оны тайландаа тусгажээ. Монгол Улсын хувьд сүүлийн 20 жилийн хугацаанд хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөлөөр дэлхийд

хоёрдугаарт, элэгний хорт хавдрын өвчлөл хамгийн өндөр, ходоодны хорт хавдрын өвчлөлөөр хоёрт эрэмбэлэгдэж байна.¹ Иргэдийн эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн тэргүүн эгнээнд хүнсний аюулгүй байдал томоохон байр суурь эзэлдэг бөгөөд иргэдийн амар тайван амьдралын төлөө тангараг өргөн зүтгэдэг цагдаагийн байгууллагын албан хаагчдын хүнсний аюулгүй байдал баталгаагүй, амьдралын чанар дундаас доогуур түвшинд байна. Энэ нь цагдаагийн албан хаагчдын сэтгэл зүйн, ажлын бүтээмж, ажлын байранд тогтвортой ажиллахад нөлөөлж байх боломжтой ба цагдаагийн албан хаагчийн хүнсний хангалтын эрх зүйн зохицуулалт ч хангалттай бус байгаа нь “Цагдаагийн байгууллагын хүнсний хангалтын менежмент”-ийг судлах түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг зорьж байна.

Үндсэн хэсэг: Хүчний байгууллагын хүнсний аюулгүй байдлыг хангахад анхаарах зарим асуудлыг томъёолохын тулд хүнсний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлийн нөлөөллүүдийг:

- Цагдаагийн байгууллагын хүнсний аюулгүй байдлын тухай онолын мэдлэг ямар төвшинд байгаа болон орчны үнэлгээнд хийсэн тойм судалгаа;

- Цагдаагийн байгууллагын хүнсний аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийг тодорхойлж, асуулгын аргаар судалгаа хийлээ.

НЭГ. ЦАГДААГИЙН АЛБАНЫ ХҮНСНИЙ

ХАНГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

§1.1. Цагдаагийн хангалт, үйлчилгээний түүхэн хөгжил

Хүний аливаа хэрэгцээ хязгааргүй байдаг. Тэр хэрэгцээг хангах нөөц боломжийг бүрдүүлж, шаардлагатай төсөв мөнгө, эд зүйлсээр хангаж зохион байгуулах ажлыг аж ахуй, санхүүгийн ажил хариуцсан байгууллага, албан тушаалтнууд хэрэгжүүлдэг.

Нөөц нь хэмжээтэй баялгаар байгууллага, хүмүүний хэрэгцээг хэрхэн яаж үр ашигтай хангах тухай асуудлыг ул суурьтай судлан шинжилж, төлөвлөн зохион байгуулж, эд баялгийн нөөцийг бүрдүүлж байгууллага, хүний хэрэгцээг цаг ямагт тасалдалгүй хангаж байдгаараа санхүүгийн байгууллага нь бусад байгууллагаас ялгарах нэгэн онцлогтой юм.

Мөнгө, санхүүгийн асуудал нь хүн төрөлхтний хөгжил дэвшилтэй хамт урагшлан хөгжсөөр өнөөгийн өндөрлөгт хүрч, төрийн албан байгууллага болон хувийн хэвшлийн корпораци, групп, компаниуд цөм санхүүгийн менежмент дээр тулгуурлан хэтийн төлөв, алсын хараагаа тодорхойлж хөгжсөөр байна.

1921 онд ялсан Ардын хувьсгалын үр дүнд шинэ тутам байгуулагдсан Цагдан сэргийлэх байгууллага нь анх байгуулагдсан цаг үеэсээ эхлэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг төр ард түмнийхээ амар амгаланг сахиулах ариун үүргийг түүхэн хөгжлийнхөө явцад биелүүлж ирсэн байна. Тухайн байгууллагын өмнө тавигдсан үүрэг

¹ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаа 2019 он

зорилтуудыг аж ахуй, санхүүгийн алба, нэгжгүйгээр бүрэн хэрэгжүүлэх боломжгүй юм.

Ер нь аж ахуй, санхүүгийн байгууллага, алба нь тухайн байгууллагыг тогтвортой хөгжих боломж бололцоогоор хангаж, найдвартай ар тал болж ажиллаж ирсэн байна.

Түүхийн баримтаас үзвэл Ардын хувьсгалтай эн зэрэгцэн бий болсон цагдан сэргийлэх байгууллага нь 1921-1939 онуудад өөрийн бие даасан аж ахуй, санхүүгийн алба нэгжгүйгээр ажиллаж, тухайн үеийн Цэргийн яам, Дотоодыг хамгаалах газар, Дотоод явдлын яамны аж ахуй, санхүүгийн байгууллагаас нэгдсэн журмаар хангалт үйлчилгээ хийж ажиллаж байсан байна.

Богдын төрийн цагдаагийн байгууллага нь шинж чанар, үйл ажиллагаараа шинэчлэгдэж, Ардын төрдөө үйлчлэх болсон боловч хуучин цагдаагийн морьт ба явган цагдаагийн системийг нэг хэсэгтээ үргэлжлүүлэн ажиллажээ.

Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан нар нь анхан үедээ хугацаат цэргийн албан хаагчийн нэгэн адил улсын сангаас хүнс, хувцсаар хангагдан ард түмнийхээ амар амгаланг сахиулах үүргээ биелүүлж байв.

Энэ байдлыг тухайн үеийн удирдлагууд анхааран үзэж, дүгнэлт хийж аж ахуй, санхүүгийн хувьд бэхжүүлэх олон талын арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байсан байна.

Зарим авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс дурдвал: 1921-1922 оны хооронд Ардын засгийн газар, Дотоод явдлын яам, Эрдэнэшанздовын яам зэрэг газраас эрх хэргэм, морьтой явган цагдаагийн талаар дүрэм дэглэж, түр

цагийн хуралд оруулж батлуулсан байна.

Морьтой цагдаа нь хар өнгийн эмжээртэй хөх өнгийн дээлэн дээр шар өнгөтэй хар эмжээртэй энгэртэй болон нуруун дээрээ соёмбо үсэг бүхий “Сэргийлэхийн морьт цагдаа”, явган цагдаа нь хар өнгийн эмжээртэй хөх өнгийн дээлэн дээр улаан хүрэн өнгийн хар эмжээртэй энгэртэй болон нуруун дээрээ “Сэргийлэхийн явган цагдаа” гэсэн бичигтэй хантаазтай байсан байна. Малгай нь бол дөрвөн талтай шовгор малгайтай, өвлийн цагт цагаан хурганы арьсыг хадаж өмсдөг байсан байна.

Монгол Улсын Засгийн газраас 1922 онд цэргийн албан хаагчдын хувцас, хүнсний нормыг анхлан тогтоожээ. Хоногийн хүнсний нормд нэг цэрэгт өдөрт 405,5 гр гурил, 810 гр мах, 4,27 гр шар тос буюу сүүл, будаа, сонгино, давс тус бүр нэг золотник /дамар/, мөн саван, тамхи олгож байжээ. Цэргийн албан хаагчдын хоногийн хүнсний энэхүү нормыг цагдаа нар нэгэн адил мөрдөж, хүнсээр хангагджээ.

1924 он гэхэд л Нийслэл хүрээний цагдан сэргийлэх хороо 116, Маймаа хотын цагдан сэргийлэх хэлтэс 32, нийтдээ 148 хүнтэй болж, хариуцах үүрэг чангарахын хэрээр сэргийлэх цагдаа нарын цалин хангамжийг нэмэгдүүлэх санал гарч, улмаар Засгийн газрын ээлжит хуралдаанаар “...Цагдан сэргийлэхийн ажилтан нь нааш цааш одох, аливаа худалдаачныг цагдах зэргээр зорчих алба үлэмж их тул эрхбиш морьт цагдаа байвал зохино...” хэмээгээд морьт, явган цагдаад сар бүр 27 лангийн цалин олгуулахаар тогтжээ.

БНМАУ-ын Засгийн газрын хурлын олон гишүүд хуралдаж зөвлөлдөн тогтсон 1926 оны 02 дугаар

05-ны өдрийн 5 дугаар хурлын тогтоолын гуравдугаар зүйлд: "...Дотоод явдлын яамнаас Улсын цагдан сэргийлэх газар болон мөн аймаг хотын газруудыг байгуулах салбаруудын 16 дугаар онд зарцуулах зүйлүүдийг тусгай комисс томилж төсөвлөсөн данс үйлдүүлэн батлан тогтоолгохоор ирүүлсэн хэрэгт Засгийн газраас хэрхэх саналыг гаргаж, зохих газар тушаасан нь саяхан улсын бүх орлого, зарлагыг төсөвлөсөн данс үйлдэх тусгай комиссоос хэлэлцээд бүгд орон тоо 133 болгохоос сургагч цагдаагийн захирал нэжгээд оронг хасч, комендат бөгөөд туслах дарга нэжгээд орон тоог нарийн бичгийн даргад хавсруулан цалинг нь 120 төгрөг болгож, сумангийн дарга 2 орны нэгийг бүрмөсөн хасч, үлдэх нэгийн цалинг сар бүр 80 төгрөгөөр тогтоож, салааны захирагч 4, морьт цагдаа 60, явган цагдаа 40-ийг хэвээр явуулж, бүгд орон 129 болгон тогтоосон байна. Ийнхүү орчин үеийн цагдаагийн байгууллага нь 1922 оноос хүнсний болон хувцасны нормыг тогтоон олгож ирсэн түүхтэй.

§1.2. Монгол Улсын болон гадаадын зарим улсын цагдаагийн байгууллагын хүнсний хангалтын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Цагдаагийн байгууллагын хүнсний хангалтын эрх зүйн орчны хувьд дараах байдлаар хууль, журамд тусган хэрэгжүүлж байна. Үүнд: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 804.6 Хүнсний болон эдийн хангалтаар хангах, хоолны зардал олгох , Цагдаа, дотоодын цэргийн албан хаагч, ажилтан өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургалт, дадлага хийх үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүнсний болон эдийн хангалтаар хангах, хоолны

зардал олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

804.6 Хоолны зардал олгох

804.6.1 Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтанд хоолны зардлыг дараах тохиолдолд олгоно:

а/ байгууллагын жижүүр, шөнийн ээлжид үүрэг гүйцэтгэх эргүүл, харуул

б/ байгууллагын даргын тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн үед шуурхай удирдлагын штаб болон хамгаалалтад үүрэг гүйцэтгэх

в/ байгууллагын даргын тушаалаар хээрийн сургууль, дадлага хийх

г/ ажлын бус цагаар үүрэг гүйцэтгэх

д/ холбогдох хуульд заасан үндэслэл журмын дагуу үүрэг гүйцэтгэх

804.6.2 Энэ журмын 804.6.1-д заасан үүрэг гүйцэтгэсэн алба хаагч, ажилтанд тухай бүр халуун хоолоор хангах боломжгүй тохиолдолд хоолны зардлыг мөнгөөр тооцон олгож болно.

Цагдаагийн албаны тухай хууль. Хуулийн 87.5. Цагдаагийн байгууллага алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургалт, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно. Цагдаагийн алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг цагдаагийн төв байгууллагын дарга тогтооно,

93.2. Энэ хуулийн 93.1-д заасан шаардлагын хүрээнд цагдаагийн алба хаагчийн хүнсний болон эдийн хангалт, сургалтын байр, сургалт, бэлтгэл, холбоо, мэдээлэл технологийн үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ, хамгаалах болон тусгай хэрэгсэл,

хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, техник хэрэгслийн зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ,

94.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга нь нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчийг орон байр, хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болно”.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 дугаар сарын 01-ий өдрийн А/310 дугаар тушаал шөнийн ээлжид 24 цагаар эргүүл, жижүүр, харуулын үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдын 1 хоногийн хоолны зардлыг 16000 төгрөгөөр, өндөржүүлсэн бэлэн байдал, хээрийн дадлага сургалтын нэг удаагийн хоолны зардлыг 8000 төгрөгөөр тооцож, тухайн жилийн батлагдсан төсөвтөө багтаан олгохыг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нарт зөвшөөрсүгэй.

Тус тушаалын хавсралтаас үзэхэд:

- Улаанбаатар хотын дүүрэг хэлтэсд 18-33 алба хаагч
- Нэгж байгууллагуудад 2-55 алба хаагч
- Аймаг цагдаагийн газар, хэлтэс 16 алба хаагч
- Сум дундын цагдаагийн хэлтэс 9 алба хаагч улсын хэмжээнд дундажаар 760 орчим алба хаагч 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.8 дахь хэсэгт “Цагдаагийн алба хаагчийг жил бүр эмнэлгийн үзлэгт хамруулж,

зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалтыг бодитойгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхээр Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах зардалд 389,5 сая төгрөг тусгуулах тооцоо, судалгаа гарган 2021 оны төсөвт тусгуулахаар саналыг 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 01/520 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн нь Улсын Их Хурлаар цагдаагийн байгууллагын төсөв батлагдах үед хасагдсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллага нь 2021 онд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Төв, орон нутгийн эрүүл мэндийн төв, Төрийн болон Төрийн бус эмнэлгийн байгууллагатай хамтран 2021 онд 7422 алба хаагч, ажилтан /5196 буюу 70 хувь нь эрэгтэй, 2226 буюу 30 хувь нь эмэгтэй/-ыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтээр амьсгалын эрхтний тогтолцооны эмгэгтэй 410, зүрх, судас, цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны эмгэгтэй 911, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгтэй 1464, бөөр шээс ялгаруулах эрхтэн тогтолцооны эмгэгтэй 1140, эмэгтэйчүүд 71, цус төлжүүлэх эрхтэн тогтолцооны эмгэгтэй 212, дотоод шүүрлийн эрхтэн тогтолцооны эмгэгтэй 650, жирэмслэлт, төрөлт төрсний дараах эмгэгтэй 31, гэмтлийн эмгэгтэй 109, мэс заслын эмгэгтэй 222, халдварт өвчин 155, мэдрэлийн эмгэгтэй 419, нүдний эмгэгтэй 463, чих, хамар хоолойн эмгэгтэй 599, хавдрын эмгэгтэй 25, арьс, харшилтай 325, яс булчин холбогч эдийн эмгэгтэй 153 алба хаагч, ажилтан илэрсэн байна.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний

дүгнэлтээр эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлсэн 225, нэн яаралтай хагалгаанд орсон 66, өдрийн эмчилгээнд хамрагдсан 601, төв, орон нутгийн сувилалд сувицуулсан 349, хоолны дэглэм барих шаардлагатай 1177, сэтгэл зүйчид хандаж зөвлөгөө авсан 19, физик эмчилгээ хийлгэсэн 381, биеийн жин хасах нэн шаардлагатай 1678 алба хаагч, ажилтан эмчилгээнд хамрагдсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилтын шалгуур үзүүлэлт 2 дугаар заалтын биелэлтийн хүрээнд Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах ажлын хүрээнд Улаанбаатар цагдаагийн хүрээний анги, байгууллагууд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, харьяа дүүргийн нэгдсэн эмнэлэг, орон нутгийн анги байгууллагууд аймгийн нэгдсэн эмнэлэг болон бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдэд үзлэг шинжилгээнд анги, байгууллагын 4398 алба хаагч, ажилтан хамрагдсан.

Цагдаа, дотоодын цэргийн 57 анги, байгууллага нь мэргэжлийн харьяа орон нутгийн эрүүл мэндийн төв, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран эрүүл мэндийн тусгай, төрөлжсөн үзлэг, шинжилгээ, оношилгоонд 9950 алба хаагч, ажилтанд үр дүнтэй зохион ажилласан нь нийт бие бүрэлдэхүүний 92% нь хамрагдсан байна.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн дүгнэлтээр амьсгалын эрхтний тогтолцооны эмгэгтэй 586, зүрх, судасны эрхтэн тогтолцооны эмгэгтэй 781, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгтэй 1406, бөөр шээс ялгаруулах эрхтэн тогтолцооны эмгэгтэй 968, эмэгтэйчүүд 85, дотоод шүүрлийн эрхтэн тогтолцооны эмгэгтэй 586, гэмтлийн эмгэгтэй 115, мэс заслын эмгэгтэй 229, мэдрэлийн эмгэгтэй 331, нүд, чих, хамар хоолойн эмгэгтэй 567, хавдрын эмгэгтэй 24, арьс, харшилтай 456, бусад эмгэгтэй 284 алба хаагч, ажилтан үзлэг шинжилгээгээр тус тус илэрсэн байна.

Гадны зарим орны эрх зүйн зохицуулалт

1. Сент Люси улс

Сент Люси улс: (Saint Lucie) нь зүүн Карибын арлуудын Вест Индийн үндсэн хуульт хаант засаглалтай арлын улс.

Сент Люси улсын Засгийн газар болон Цагдаагийн нийгмийн халамжийн холбоо хооронд 2016 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр байгуулсан хамтарсан гэрээний 36-дугаар зүйлд (Meal allowance) буюу Цагдаагийн албан хаагчийн хоолны хөнгөлөлтийн талаар зохицуулжээ.

Уг гэрээний 36.1 дүгээр зүйлд Ажил олгогч дараах албан хаагчдад 25 долларын урамшуулал олгоно. Үүнд:

-Өдрийн хоолны цайны цагаар ажилласан албан хаагч

-Ажиллавал зохих цагаас илүү цагаар ажилласан албан хаагч

36.1 The Employer agrees that a meal allowance of twenty-five dollars (\$25.00) shall be paid to an employee who:

- is authorized to work through their lunch hour

• is required to work overtime beyond their stipulated hours.

36.2 дугаар зүйлд: Ажил олгогч 7 цагаас өмнө ажиллах шаардлагатай албан хаагчид өглөөний цайны мөнгө болох 18 доллар олгоно.

36.2 The Employer shall pay a breakfast allowance of eighteen (\$18.00) to non-shift employees who are required to start work before 7:00am.

2.Их британи

Их британи Умард Ирландын вант улсын Цагдаагийн албан хаагчын хоол хүнсний тэтгэмжийн хэмжээг тогтоосон төрийн эрх бүхий хууль тогтоох байгууллагаас баталсан хууль байдаггүй гэхдээ (Police regulation 2003) буюу 2003 онд батлагдсан Цагдаагийн албан хаагчын дүрмийн 35 дугаар зүйлийн 35.1-д Цагдаагийн албан хаагч албан үүрэг гүйцэтгэх үед гарсан зардлыг нөхөн төлнө гэж зүйлчлэн заасан байна. (article 35.1 The Secretary of State shall determine the entitlement of members of a police force to reimbursement of any expenses incurred by such a member in or in connection with the execution of his duty.)

Энэ заалтыг үндэслэл болгон Их британи Умард Ирландын Нэгдсэн вант улсын муж болгон өөр, өөр хэмжээгээр цагдаагийн албан хаагчын хоол хүнсний тэтгэмжийн хэмжээг тогтоодог байна.

Уг хэмжээг тогтоохын тулд тухайн мужийн цагдаагийн газар, тухайн орон нутгийн засаг даргын тамгийн газар хамтран (Collective agreement, Collective bargaining agreement) зарим тохиолдолд Negotiate agreement буюу хамтын гэрээ хийдэг байна.

Жишээ болгож Их британийн баруун Иоркшэйр мужийн цагдаагийн газрын хамтын гэрээг дараах байдлаар харуулав:

Тус цагдаагийн газрын албан хаагч албан үүрэг гүйцэтгэх хугацаандаа хоолны зардалд зарцуулсан өөрийн мөнгөө худалдан авсан хоол хүнсний баримтыг цагдаагийн газартаа өгснөөр хоол хүнсэнд зарцуулсан мөнгөө буцаан авдаг байна.

Албан хаагч өглөөний цай (Breakfast) 7.50

Өдрийн хоолонд (Lunch) 10

Оройн хоолонд 20 хүртэлх Фунтын хоол хүнсний тэтгэмжийн мөнгийг буцаан авах боломжтой байна.

Хэрэв худалдан авсан хоол хүнс нь уг гэрээнд заасан үнийн дүнгээс бага байвал нэмэлтээр өөр бүтээгдэхүүн худалдан авахыг хориглоно. (Өдрийн хоол гэхэд 1 хоол хүнс худалдаж авсан баримт байх ёстой.) Хэрэв эмнэлгийн дэглэм барьдаг gluten free хоол хүнс хэрэглэх зайлшгүй шаардлагатай бол нэмэлтээр худалдан авахыг зөвшөөрнө.

Эдгээр худалдан авсан хоол хүнс нь зөвхөн цагдаагийн албан хаагч албан үүрэг гүйцэтгэх үед гарсан байхыг шаардана. Хэрэв албан үүрэг гүйцэтгээгүй, энгийн үед худалдан авсан бол хоол хүнсний тэтгэмжийг олгохгүй.

Худалдан авсан хоол хүнс нь заавал худалдан авсан он сар өдөр, баримттай байхыг шаардана, Хоол хүнсний баримт нь заасан хэвэлсэн, аж ахуй нэгж байгууллагын бүртгэлийн дугаар, холбогдох мэдээлэлтэй байна.

Энэхүү хөнгөлөлөтөнд Алкогол бүхий уух зүйл хамаарахгүй.

Бүлгийн дүгнэлт

Дээрх хуулийн заалт, журам, тушаалуудаас үзэхэд цагдаагийн байгууллагад албан үүргээ гүйцэтгэж байгаа 13,000 гаруй алба хаагч ажилчдын хүнсний хангалтын талаарх хууль, журам, тушаал тодорхой бус

хэтэрхий ерөнхий зарим тохиолдолд газар нэгжүүдэд хариуцан хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтан байхгүй.

Цагдаагийн төв байгууллагын даргын А/310 тушаал нь ямар үндэслэлээр 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч, ажилчдын хоолны зардлыг арван зургаан мянган төгрөг, өндөржүүлсэн бэлэн байдал, хээрийн дадлага сургалтын нэг удаагийн хоолны зардлыг найман мянган төгрөгөөр тооцож олгож байгаа нь тодорхой бус зөвхөн 1 удаа л хоол худалдан авах боломжтой мөн цагдаагийн албаны тухай хуулийн 87.5 Цагдаагийн байгууллага алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургалт, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно гэсэн хэдий ч байнга илүү цагаар болон ажлын бус цагаар үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад (код 804.6 зүйлд заасан хоолны зарцуулалтыг бүрэн тусгаж өгөөгүй нь учир нь дутагдалтай байна.)

Мөн нийслэл, аймаг дүүргийн хэлтэсүүд уртасгасан цагаар, баяр наадам, төрийн өндөр хэмжээний албан айлчлал, жагсаал цуглаан бэлэн байдлын үе болон 7 хоногийн 5 өдөр болон уртасгасан цагаар шөнийн 04 цаг хүртэл нэмэлтээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын хүнсний зардал, хангалтгүйгээс баталгаагүй газраас хүнсний эрүүл ахуйн шаардлага хангаагүй худалдааны цэгүүдээс түргэн хоол, бэлэн хоол, ширхэгийн хоолоор үйлчлүүлж сэтгэл санаа, эрүүл мэнд болон санхүүгийн байдлаар хохирч байна.

Дээрх судалгаануудаас хархад цагдаагийн албан хаагчид шөнийн болон илүү цагаар байнга үүрэг

гүйцэтгэдэг ч хүнсний хангалт болон нөхөн амралт байхгүй улмаас эрүүл мэндээр хохирч байгаа ба цаашид албан хаагчдын буруу хооллолтын талаарх анхан шатны мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай байгаа нь доорх эрүүл мэндийн судалгаанаас харагдаж байна.

1. Бодисын солилцооны үйл ажиллагааны алдагдал

Нэг суугаад их хэмжээний хоол идэх нь цусан дахь сахрын хэмжээ, инсулины түвшинд мэдэгдэхүйц хэлбэлзэл үүсгэж, инсулины эсэргүүцэл үүсгэдэг. Цаг хугацаа өнгөрөхөд энэ нь 2-р хэлбэрийн чихрийн шижин өвчний хөгжилд хувь нэмэр оруулж магадгүй юм. Тогтворгүй хооллолт нь циркадийн хэмнэлийг алдагдуулж, бодисын солилцооны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, таргалалт, чихрийн шижин, зүрх судасны өвчнөөр өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлдэг болохыг судалгаагаар тогтоожээ. Тогтмол бус хооллолт нь глюкозын солилцоог алдагдуулж, инсулины эсэргүүцэл болон бодисын солилцооны синдром үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг болохыг судалгаагаар тогтоосон. "Diabetes Care" сэтгүүлд хэвлэгдсэн судалгаагаар хооллох цаг, хэт их идэх нь бодисын солилцооны үйл ажиллагааг алдагдуулдаг болохыг тогтоожээ.

2. Жин нэмэх ба таргалалт

Нэг суугаад хэт их идэх нь илүүдэл илчлэгийг хэрэглэхэд хүргэдэг бөгөөд энэ нь биед өөх тос хэлбэрээр хадгалагддаг. Цаг хугацаа өнгөрөхөд энэ нь жин нэмэх, таргалалтад хувь нэмэр оруулдаг, ялангуяа хөдөлгөөний дутагдалтай хавсарсан тохиолдолд бие махбод нэг хоолонд их хэмжээний хоол боловсруулах гэж тэмцэж, бодисын солилцооны хурд удааширч, өөх тосыг хэрэглэхээс илүүтэйгээр өөх тосыг хадгалахад хүргэдэг. Үе үе хэтрүүлэн

идэх нь таргалах эрсдэлийг ихээхэн нэмэгдүүлдэг болохыг судалгаагаар тогтоожээ. Journal of Nutrition сэтгүүлд нийтлэгдсэн судалгаагаар хэт их идэх зан үйл нь жин нэмэх, таргалалттай шууд холбоотой болохыг онцлон тэмдэглэжээ.

3. Зүрх судасны асуудал

Зохисгүй хооллолт, хэт их идэх нь цусан дахь холестерин хэмжээг нэмэгдүүлж, цусны даралтыг нэмэгдүүлж, атеросклероз (судасны хатуурал) үүсгэдэг бөгөөд энэ нь зүрхний өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг. Их хэмжээний хоол идэх, ялангуяа ханасан өөх тос, сахар ихтэй хоол идэх нь цусан дахь липидийн хэмжээг нэмэгдүүлж, зүрх судасны ачаалалд нөлөөлдөг. The American Journal of Clinical Nutrition сэтгүүлийн судалгаагаар байнга хэтрүүлэн иддэг эсвэл тогтмол бус хооллодог хүмүүс зүрх судасны өвчнөөр өвчлөх магадлал өндөр байдаг. Хэт их идэх нь цусан дахь холестерин, триглицеридын хэмжээ ихсэх зэрэг липидийн эмгэгийг үүсгэдэг бөгөөд энэ нь зүрхний өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг.

4. Ходоод гэдэсний замын асуудал

Удаан хугацааны мацаг барьсны дараа их хэмжээний хоол идэх нь ходоодны хямрал, гэдэс дүүрэх, хүчиллэгийг бий болгодог. Хэт их идэх нь хоол боловсруулах эрхтний үйл ажиллагааг дарангуйлж, таагүй байдал, ходоодны хоосолтыг удаашруулж, ходоод-улаан хоолойн сөргөө өвчин (GERD) үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Gut сэтгүүлд хэвлэгдсэн судалгаагаар тогтмол бус хооллолт нь их хэмжээний хоолтой хослуулан диспепси, хүчиллэг рефлюкс зэрэг ходоод гэдэсний өвчин үүсгэх магадлалыг нэмэгдүүлдэг болохыг тогтоожээ.

5. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал

Хоолоо алгасах, дараа нь хэтрүүлэн идэх нь сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, сэтгэлийн түгшүүр, сэтгэлийн хямрал, стрессийг үүсгэдэг. Энэ мөчлөг нь сэтгэл хөдлөлийн хооллолт, хэт их идэх эмгэгийг бий болгож, сэтгэл зүйн хямрал, биеийн дүр төрхийг зовоодог. Тогтворгүй хооллолт ба сэтгэцийн эрүүл мэндийн хоорондын хамаарлыг сайн баримтжуулсан байдаг. American Journal of Psychiatry сэтгүүлд хийсэн судалгаагаар тогтмол бус хооллодог хүмүүс сэтгэлийн түгшүүр, сэтгэлийн хямрал, хэт их идэх эмгэг зэрэгт өртөх эрсдэл өндөртэй байдаг.

6. Хоол тэжээлийн дутагдал

Тогтмол бус хооллолт нь хувь хүн шим тэжээлийг тэнцвэртэй хэрэглэхээс сэргийлж, витамин, эрдэс бодисын дутагдалд хүргэдэг. Хоолны дэглэм нь нэг том хоолонд төвлөрсөн үед ерөнхий эрүүл мэндэд шаардлагатай олон төрлийн тэжээллэг бодисууд, тухайлбал А, С, Д витаминууд, кальци, төмөр зэрэг эрдэс бодисууд дутагддаг. British Journal of Nutrition сэтгүүлд хооллох цагийг тогтмол бус, ялангуяа хэт их идэхтэй хослуулсан нь хангалттай тэнцвэртэй хооллолт хэрэглэх магадлалыг бууруулж, ерөнхий эрүүл мэндэд нөлөөлдөг шим тэжээлийн дутагдалд хүргэдэг болохыг талаар дурдсан байдаг.

4.3.1. Ажлын байрны орчин нөхцөл

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 77 23 дугаар зүйлийн 1-д “Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй” гэж, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон

улсын пактын 78 7 дугаар зүйлийн (b)-д “Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрөх бөгөөд аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон ажлын нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй” гэж тус тус заажээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй” гэж, “Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь хэсэгт “төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах баталгаагаар хангагдана” гэж цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхийг баталгаажуулжээ.

4.3.2. Ажлын ачаалал, цалин хөлс

Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшууллаас бүрдэнэ.” гэж, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Ажилтанд үндсэн цалин дээр нь ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс олгож болно” гэж, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт “Шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд олгох нэмэгдүүлсэн цалин хөлсийг хамтын ба хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна” гэж, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь хэсэгт “тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын

цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ” гэж тус тус заасан байдаг.

Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ыг баталсан ба уг тогтоолоор “1 хэсгийн байцаагч 4 000 хүн ам тутамд, хэв журмын эргүүл нийслэлд 15 000 хүн ам тутамд хоёроос доошгүй, аймгийн төвд 5 000 хүн ам тутамд нэгээс доошгүй, эргүүлийн нэг чиглэлд хоёр албан хаагч үүрэг гүйцэтгэх” гэж жишиг норматив тогтоосон байна. Судалгаанд хамрагдсан нийт алба хаагчаас “Та өдөрт хэдэн цаг ажилладаг вэ?” гэсэн асуултад 5 хувь нь өдөрт 8 цаг хүртэл, 22 хувь нь 8-10 цаг, 33 хувь нь 10-12 цаг, 40 хувь нь 12 цагаас дээш хугацаагаар ажилладаг гэж хариулжээ.

Цагдаагийн ерөнхий газраас нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг нэг загвараар баталсан бөгөөд үүнд илүү цагаар ажиллах шаардлага тусгасан нь Төрийн албаны тухай хууль зөрчиж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу 1 ажилтан сард 160 цаг, жилд 1760 цаг ажиллах ёстой боловч нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагч 7 хоногийн 6 өдөр буюу хамгийн багадаа сард 192 цаг, жилд 2112 цаг ажиллаж байна. Гэтэл тэд жилд хамгийн багадаа 352 цаг илүү цаг ажиллаж байна. Үүнд шуурхай цугларалт, албаны бэлэн байдал, хүчлэн хамгаалалт зэрэг онцлог цаг үеэр ажиллуулсныг тооцоогүй болно.

4.3.3. Хувцас, ахуй хангамж

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 4 дүгээр сарын 9-ний

өдрийн “Хүнсний хангалтын тухай” 2/8 дугаар тушаалаар алба хаагчдын нэг хоногийн хоолны зардлыг дараах байдлаар баталсан байна. Үүнд:

- Эргүүл, жижүүрийн үүргийг 24 цагаар гүйцэтгэж буй алба хаагчдын нэг хоногийн хоолны зардалд 3600 төгрөг;

- Өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллагчдын болон хээрийн сургууль, дадлага, албаны нэгдсэн сургалтад суралцагчдын нэг хоногийн хоолны зардалд 5000 төгрөг.

Нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий алба хаагчдад нэг хоногийн хоолны зардлыг олгохдоо хэлтсийн ойролцоох болон хэлтэс доторх цайны газартай гэрээ байгуулан бэлэн хоол өгөх, эсхүл тухайн өдөр нь бэлэн мөнгө өгөх, эсхүл цалин дээр нэмж бодох гэсэн хэлбэрээр олгож байна.

Шигтгээ:

“Хүнсний хангалт буюу хоолны мөнгө, хор саармагжуулах бүтээгдэхүүн”-ний хангалтын талаарх нээлттэй асуултад 3600 төгрөгөөр байнга бэлэн гоймон, ширхэгийн хоол авч иддэг, 24 цагаар үүрэг гүйцэтгэж байгаа үед зөвхөн нэг удаагийн хоолны мөнгө олгодог нь хүндрэлтэй байдаг хэмээн ярьж байлаа. (Хэлтэс, тасгийн дарга болон нийт алба хаагч нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас)

Хүн хоногт физиологийн хувьд хамгийн багадаа 2-3 удаа хооллох шаардлагатай байдаг. Гэтэл 24 цагаар үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагч 3600 төгрөгөөр эдийн засгийн хувьд 2-3 удаа хооллох ямар ч боломжгүй юм.

4.3.5. Эрүүл мэндийн асуудал

Цагдаагийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4 дэх хэсэгт “Цагдаагийн ажилтан, албан хаагч нь Иргэний эрүүл мэндийн

даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэж бэртсэний улмаас гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг Засгийн газар хариуцах баталгаагаар хангагдана” гэж заасан байдаг.

Нийслэлийн төвийн 6 дүүрэг дэх цагдаагийн 14 хэлтэс, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулдаг боловч дараах нийтлэг зөрчил илэрсэн болно. Үүнд:

- Эрүүл мэндийн үзлэгт хамруулахдаа алба хаагчдын жин, өндөр, нүдний хараа, эхо гэх мэт үндсэн үзлэгт хэлбэрийн төдий хамруулсан болж, дараа дараагийн шатны арга хэмжээ авахгүй байна.

- Үзлэгт хамруулсан бүртгэл дутуу, бүрдүүлэлт хангалтгүй.

- Эмнэлгийн нарийн мэргэжлийн үзлэг, оношлогоонд хамруулдаггүй.

- Зарим газар, хэлтэс нь алба хаагчдаас эрүүл мэндийн үзлэгийн төлбөрийг гаргуулсан байна.

Улаанбаатар хотын Цагдаагийн газрын 2015 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 8а2/393 дугаар албан бичигт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчдаас 2013, 2014 оны байдлаар мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас ажлын байрнаас чөлөөлөгдсөн хүн байхгүй байна.

Шигтгээ:

...ажлын ачааллаас үүдэлтэй элэг, зүрх судасны өвчинд нэрвэгдэх, стресст орох, олдсон үед нь хямд төсөр хоол иддэгээс болж ходоод, нойр булчирхай, цөс өвдөх, хүйтэн нөхцөлд гадаа ажилладаг учир бөөр, нуруу өвдөх,

эрэгтэй нь түрүү булчирхай үрэвсэх, эмэгтэй нь давсаг үрэвсэх (цистит) нь түгээмэл байдаг. Гэтэл бидэнд үзүүлэх эмнэлгийн нэгдсэн тусламж үйлчилгээ байдаггүй. Эмэгтэй алба хаагч эмчийн хяналтад орж чадалгүй амаржсан тохиолдол ч бий. (Цагдаагийн алба хаагч нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас)

Зөвлөмжийн хураангуй:

Тогтмол, тэнцвэртэй хоол: Хэт их идэхээс зайлсхийхийн тулд хоолоо тарааж, эрчим хүчний түвшнийг тогтвортой байлгах.

Эрүүл зууш: Хүндрэл учруулахгүйгээр эрчим хүчний түвшнийг хадгалах шим тэжээлээр баялаг хөнгөн зууш сонго.

Шингэнтэй байгаарай: Их хэмжээний ус ууж, кофейн эсвэл чихэрлэг ундаанаас зайлсхий.

Стрестэй хооллолт: Хоол идэх сэтгэл хөдлөлийн өдөөгч хүчин зүйлүүдэд анхаарлаа хандуулж, стресс тайлах эрүүл аргыг хэрэглээрэй.

Ээлжийн ажилд зориулж хоолоо төлөвлө: Хоолны дэглэмийг тогтмол бус болгохгүйн тулд ээлжийн цагийн хуваарьтай тохируул.

Завсарлагадаа бэлд: Ачаалал ихтэй өдрүүдэд ч сайн хооллолтыг хангахын тулд эрүүл, зөөврийн хоол бэлдээрэй.

САНАЛ

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 87.5-д заасны дагуу цагдаагийн албан хаагчдын хүнсний хангалтыг инфляцын түвшинтэй уялдуулж нэмэх мөн уртасгасан цагаар үүрэг гүйцэтгэх үед хүнсний зардлыг тогтмол олгох;

2. Өндөржүүлсэн бэлэн байдал, алс хол, төв суурин газраас алслагдмал газруудад ажиллах, илүү цагаар үүрэг гүйцэтгэх үед хүнсний хангалтыг хэрхэн зохион байгуулах талаар

тодорхой хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

3. Нийт цагдаагийн алба хаагчдад буруу хоололт болон ашигтай хүнсний давуу талын тухай сургалтанд хамруулах;

4. Хөнгөлөлтэй үнээр үйлчилдэг цайны газартай болох эсвэл хоол хийж идэх тав тухтай орчин нөхцөлөөр хангаж өгөх;

5. Гадаадын орнуудын цагдаагийн албаны хүнсний хангалтын талаарх мэдээллийг судалж нэвтүүлэх саналтай байна.

Гадаад орчны тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд:

- орон нутаг дахь хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт, олдоцыг сайжруулах;

- хүнсний бүтээгдэхүүнийг зориулалтын автомашинаар аюулгүй байдлыг хангаж тээвэрлэх;

- хүнсний аюулгүй байдлыг хангах журам боловсруулах зэрэг болно.

Дотоод орчны тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд:

- хүнсний хангалт, аюулгүй байдлыг хангах мэргэжилтэнтэй болох;

- хүнсний аюулгүй байдал алдагдсанаас болж алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

- хүнсний хангалтын чанар, аюулгүй байдалд тавих шат дараалсан хяналт, шалгалтыг 28 хувиар нэмэгдүүлэх;

- хүнсний бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийн чанар байдлыг сайжруулах;

- албан ажлын ачаалалтай уялдуулан хүнсний хангалтын төрөл, нормыг нэмэгдүүлэх зэрэг болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ:

1. Хоол тэжээлийн сэтгүүл,
"Хэт идэх ба таргалалтын эрсдэл"
УБ.,2019 он.

2. "Тогтмол бус хооллолт ба
ходоод гэдэсний асуудал." УБ.,2019 он.

3. Америкийн сэтгэцийн эмгэг
судлалын сэтгүүл, "Хоолны хэв маяг
ба сэтгэцийн эрүүл мэндийн үр дүн."
2020 он.

4. Британийн хоол тэжээлийн
сэтгүүл, "Тогтмол бус хооллолттой

холбоотой шим тэжээлийн дутагдал"
2021 он.

5. Цагдаагийн ерөнхий газрын
мэдээлэл, дүн шинжилгээний хэлтсийн
эрүүл мэндийн урьдчилсан судалгаа
2021 он.

6. Монгол улс дахь хүний эрх,
эрх чөлөөний байдлын талаарх 14
илтгэл 2015 он